ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг; dundgovi@audit.gov.mn

2024-03-25 № 113

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭДАЛАЙ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ЛХАГВАМАНДАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 203 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд татварын орлогын төлөвлөгөөг 28.1 хувиар, 7 нэр төрлийн орлогыг тасалж, татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлтийн хангах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй. Мөн Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан төсөл хэрэгжүүлэгчид үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс нийт 41,991.0 мянган төгрөгийн хохирол учруулжээ. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зураг төсөв, эдийн засгийн тооцоо судалгаа хийгдээгүй, магадлалаар баталгаажуулаагүй арга хэмжээнд зарцуулахаар

баталсан, нэмэлт гэрээ байгуулсан зэрэг зөрчил нь тайлант үеийн удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байлаа.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 4 хөтөлбөр, 13 зорилт, 64 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 93.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Засаг даргын Тамгын газар | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | | 1 | | | | | |
| 3 | Мал хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |
| 5 | Орон нутгийн хөгжлийн | 1 | | 1 | | | | | |
| 6 | Байгаль хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| | **НИЙТ** | 6 | 1 | 5 | | 1 | | | |

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 234,054.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 45,869.7 мянган төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 111,365.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага, 63,189.0 мянган төгрөгийн 2 заалт зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 62.3 хувийг залруулагдаагүй, 37.7 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

| № | Аудитын нэр | Аудитын дүгнэлт | Нийт зөрчил | | | | | | . | | | | | | Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн | | Нийцсэн байх батламж мэдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Зөрчил | | Алдаа | | Нийт | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | | | | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| **А** | **Б** | | **1** | **2.0** | **3** | **4.0** | **5** | **6.0** | **7** | **8.0** | **9** | **10.0** | **11** | **12.0** | **17** | **18.0** | |
| 1 | Эрдэнэдалай сумын ТТЗ | | 2 | 279,710.6 | | | 2 | 279,710.6 | | | 2 | 279,710.6 | | | 2 | 279,710.6 | 279,710.60 |
| 2 | Эрдэнэдалай сумын ТЗС | Хамруулах | 1 | 3,189.0 | 1 | 10,400.0 | 2 | 13,589.0 | | | | | 1 | 3,189.0 | 1 | 3,189.0 | |
| 3 | Эрдэнэдалай сумын ИТХ | Хамруулах | 4 | 4,276.9 | | | 4 | 4,276.9 | 1 | 618.7 | 3 | 3,658.2 | | | 4 | 4,276.9 | |
| 4 | Эрдэнэдалай сумын ЗДТГ | Зөрчилгүй | 4 | 43,668.1 | 2 | 3,221.5 | 6 | 46,889.6 | 1 | 3,260.0 | 3 | 40,408.1 | | | 4 | 43,668.1 | 42,693.10 |
| 5 | Эрдэнэдалай сумын ОНХС | Хамруулах | 2 | 127,299.5 | - | - | 2 | 127,299.5 | | | 1 | 67,299.5 | 1 | 60,000.0 | 2 | 127,299.5 | 127,299.50 |
| 6 | Эрдэнэдалай сумын ХХСан | Хамруулах | 5 | 41,991.0 | | | 5 | 41,991.0 | 5 | 41,991.0 | | | | | 5 | 41,991.0 | 41,991.00 |
| | | | | | | | | | | | | | | | | | |
| **Эрдэнэдалай сумын ТТЗ-ийн дүн** | | | **18** | **500,135.08** | **3** | **13,621.5** | **21** | **513,756.5** | **7** | **45,869.7** | **9** | **391,076.4** | **2** | **[illegible]3,189.0** | **18** | **500,135.1** | **491,694.2** |

Бэлтгэсэн: Аудитор Т.Оюун-Эрдэнэ

Хянасан: Аудитын менежер Х.Наранцацрал

Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох

Засаг дарга: Б.Лхагвамандал

Санхүүгийн албаны дарга: А.Соёл-Эрдэнэ

**Байгууллагын нэр: Эрдэнэдалай сумын Засаг дарга**

**Тайлант хугацаа: 2023 он**

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| **А** | **1** | **3** | **4** | **5** | **6** | **7** | **8** | **9** | **10** |
| | | | | **Засаг даргын Тамгын газар** | | | | | |
| 1 | Зардлын данстай холбоотой асуудал | Цалингийн зардлыг үр дүнгийн тайланд дутуу, ХХОАТ-ын өглөгийг санхүүгийн байдлын тайланд тайлагнаагүй. | 2,266,927 | Санхүүгийн тайланд залруулга хийх | Хүлээн зөвшөөрсөн. | Санхүүгийн тайланд залруулга хийх | Санхүүгийн тайланд залруулга хийх | Дарга, нягтлан бодогч | Г.Энхдэлгэр, Ж.Хишигсүрэн |
| 2 | | Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас бөглөж баталгаажуулаагүй илүү цагийн хөлс олгосон. | 39,433,132 | Албан шаардлага өгөх | Хүлээн зөвшөөрсөн. | Албан шаардлагын хэрэгжилтийг 2024.03.25-ны өдрийн дотор ирүүлэх. | Албан шаардлага өгөх | Дарга, нягтлан бодогч | Г.Энхдэлгэр, Ж.Хишигсүрэн |
| 3 | | Цалингийн зардлаас нэг удаагийн шинжтэй урамшуулал олгосон | 975,000 | Албан шаардлага өгөх | Хүлээн зөвшөөрсөн. | Албан шаардлагын хэрэгжилтийг 2024.03.25-ны өдрийн дотор ирүүлэх. | Албан шаардлага өгөх | Дарга, нягтлан бодогч | Г.Энхдэлгэр, Ж.Хишигсүрэн |
| 4 | | Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлтгэж, зарцуулсан | 3,260,000 | Төлбөрийн акт тогтоох | Хүлээн зөвшөөрсөн. | Төлбөрийн актыг 2024.05.25-ны өдрийн дотор барагдуулах. | Төлбөрийн акт тогтоох | Дарга, нягтлан бодогч | Г.Энхдэлгэр, Ж.Хишигсүрэн |
| 5 | Үндсэн хөрөнгийн данстай холбоотой | Бусад биет бус үндсэн хөрөнгийн дансанд элэгдлийн зардал тооцсон. /Газар/ | 954,529.68 | Санхүүгийн тайланд залруулга хийх | Хүлээн зөвшөөрсөн. | Санхүүгийн тайланд залруулга хийх | Санхүүгийн тайланд залруулга хийх | Дарга, нягтлан бодогч | Г.Энхдэлгэр, Ж.Хишигсүрэн |
| 6 | Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал | Тайлант хугацаанд мэдээлэх 35 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй. | - | Албан шаардлага өгөх | Хүлээн зөвшөөрсөн. | Албан шаардлагын хэрэгжилтийг 2024.03.25-ны өдрийн дотор ирүүлэх. | Албан шаардлага өгөх | Дарга, нягтлан бодогч | Г.Энхдэлгэр, Ж.Хишигсүрэн |
| | **ЗДТГ-ын дүн** | | **46,889,588.28** | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мал хамгаалах сан | Авлага барагдуулаагүй. | 3,188,980.00 | Зөвлөмж өгөх | Хүлээн зөвшөөрсөн | Өвсний авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж, эзэн тодорхойгүй 650.0 мянган төгрөгийн авлагыг эзэнжүүлж, барагдуулах. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2024.10.25-ны өдрийн дотор ирүүлэх | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | Б.Лхагвамандал, Т.Энхбат |
| 3 | Байгаль хамгаалах сан | Санхүүгийн тайланд авлагыг дутуу тайлагнасан | 10,400,000.00 | Санхүүгийн тайланг залруулах | Хүлээн зөвшөөрсөн | Санхүүгийн тайланд залруулга хийх | Санхүүгийн тайланг залруулах | Дарга, нягтлан бодогч | Б.Лхагвамандал, Т.Энхбат |
| **ТЗС-ын дүн** | | | **13,588,980.00** | | | | | | |
| Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | | | | | | | | | |
| 1 | Цалин хөлсний зардал | Сул орон тоонд түр орлон гүйцэтгэж буй ажилтанд удаан жилийн болон орон нутгийн нэмэгдлийг тооцож олгосон | 618,773.07 | Төлбөрийн акт тогтоох | Хүлээн зөвшөөрсөн | Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжилтний сул орон тоонд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа албан хаагчид олгож буй цалингийн нэмэгдлийг зогсоох; | Төлбөрийн акт тогтоох | ИТХ-ын нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч | С.Нямаа Ж.Хишигсүрэн |
| 2 | Цалин хөлсний зардал | Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нь өөртөө шийдвэр гаргаж Эрх бүхий албан тушаалтны нэмэгдлийг нэмж тогтоож олгосон. | 958,200.00 | Албан шаардлага өгөх | Хүлээн зөвшөөрсөн | Эрх бүхий албан тушаалтны нэмэгдлийг томилохэрх бүхий удирлагын шийдвэрээр хуульд заасан хувь хэмжээнд нийцүүлэн тогтоож олгох | Албан шаардлага өгөх | ИТХ-ын нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч | С.Нямаа Ж.Хишигсүрэн |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Шилэн дансны бүртгэл | Шилэн дансанд төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой гарсан шийдвэрийг байршуулаагүй, өнмөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй | - | Албан шаардлага өгөх | Хүлээн зөвшөөрсөн | шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах; | Албан шаардлага өгөх | ИТХ-ын нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч | С.Нямаа Ж.Хишигсүрэн |
| 4 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал | Анхан шатны баримтын бүрдэл хангалттүй баримтад үндэслэн сургалтын төлбөрийн зардлыг зарцуулсан. | 2,700,000.00 | Албан шаардлага өгөх | Хүлээн зөвшөөрсөн | Анхан шатны баримтын бүрдлийг хангах, хяналт тавих, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх | Албан шаардлага өгөх | ИТХ-ын нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч | С.Нямаа Ж.Хишигсүрэн |
| | ИТХ-ын дүн | | 4,276,973.07 | | | | | | |
| | | | | | **Орон нутгийн хөгжлийн сан** | | | | |
| 1 | Зардал | Хүүхэд хөгжлийн ордон тоног төхөөрөмж, суурилуулалт, дагалдах болон холболтын тоног төхөөрөмжийг нэмэлт гэрээ байгуулсан. | 60,000,000.0 | Зөвлөмж өгөх | Засаг дарга Б.Лхагвамандал, Засаг даргын орлогч О.Базаррагчаа Санхүүгийн албаны дарга А.Соёл-Эрдэнэ, Нягтлан бодогч Т.Энхбат нарт 2024 оны 01 дүгээр сарын 29-ны танилцуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн | Төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх | Зөвлөмж өгөх | Засаг дарга, Засаг даргын орлогч, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч | Б.Лхагвамандал О.Базаррагчаа А.Соёл-Эрдэнэ Т.Энхбат |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Хөрөнгийн зардал | ОНХС-ийн хөрөнгийг зураг төсөв, эдийн засгийн тооцоо судалгаа хийгдээгүй, магадлалаар баталгаажуулаагүй 4 арга хэмжээнд зарцуулахаар баталсан. | 67,299,500.0 | Албан шаардлага хүргүүлэх | Б.Лхагвамандал, Засаг даргын орлогч О.Базаррагчаа Санхүүгийн албаны дарга А.Соёл-Эрдэнэ, Нягтлан бодогч Т.Энхбат нарт 2024 оны 01 дүгээр сарын 29-ны танилцуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн | Хууль тогтоомжийг мөрдөж ажиллах. | Зөрчлийг давтан гаргуулахгүй байх хугацаатай албан шаардлага хүргүүлсэн | Засаг дарга, Засаг даргын орлогч, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч | Б.Лхагвамандал О.Базаррагчаа А.Соёл-Эрдэнэ Т.Энхбат |
| | м | | 127,299,500.0 | | | | | | |
| **Хоршоо хөгжүүлэх сан** | | | | | | | | | |
| 1 | Балансын данстай холбоотой | Эрдэнэдалай сумын төсөл хэрэгжүүлэгч Б.Жавзмаа 4,215,183.00 /Дөрвөн сая хоёр зуун арван таван мянга нэг зуун наян гурав/, Н.Мягмарсүрэн 2,556,762.00 /Хоёр сая таван зуун тавин зургаан мянга долоон зуун жаран хоёр/, Уран зүүний шаглаа ХХК 29,635,355.00 /Хорин есөн сая зургаан зуун гучин таван мянга гурван зуун тавин тав/, А.Жаргалдэлгэр 2,468,911.00 /Хоёр сая дөрвөн зуун жаран найман мянга есөн зуун арван нэг/, О.Нармандах 3,114,819.00 /Гурван сая нэг зуун арван дөрвөн мянга найман зуун арван ес/ төгрөгийн үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс Хоршоо хөгжүүлэх санд нийт 41,991,030.00 /Дөчин нэгэн сая есөн зуун ерэн нэгэн мянга гуч/ төгрөгийн хохирол учруулсан | 41,991,030.0 | Төлбөрийн акт тогтоох | Аудиторын саналыг хүлээн зөвшөөрч, зөрчлийг арилгана | Заасан хугацаанд зөрчлийг арилгаж, биелэлтийг ирүүлэх | Төлбөрийн акт тогтоосон | Дарга, Нягтлан бодогч | Б.Лхагвамандал, Т.Энхбат |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Тайлант хугацаанд мэдээлэх 21 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй | - | Албан шаардлага хүргүүлэх | Хүлээн зөвшөөрсөн. | Биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор | Албан шаардлага хүргүүлэх | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Б.Лхагвамандал, А.Соёл-Эрдэнэ |
| 2 | Орлого бүрдүүлэлттэй холбоотой | Татварын орлогын төлөвлөгөөг 28.1 хувиар, 7 нэр төрлийн орлогыг тасалж, татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлтийн хангах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй | 279,710,600.00 | Албан шаардлага хүргүүлэх | Хүлээн зөвшөөрсөн. | Биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор | Албан шаардлага хүргүүлэх | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Б.Лхагвамандал, А.Соёл-Эрдэнэ |
| **ТТЗ-ын дүн** | | | **279,710,600.00** | | | | | | |
| **Нийт дүн** | | | **513,756,671.35** | | | | | | |

Бэлтгэсэн: Аудитор Т.Оюун-Эрдэнэ

Хянасан: Аудитын менежер Х.Наранцацрал

Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох

Засаг дарга: Б.Лхагвамандал

Санхүүгийн албаны дарга: А.Соёл-Эрдэнэ

**Байгууллагын нэр: Эрдэнэдалай сумын Засаг дарга**

**Тайлант хугацаа: 2023 он**

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Тайлант хугацаанд мэдээлэх 21 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй | - | Албан шаардлага хүргүүлэх | Хүлээн зөвшөөрсөн. | Биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор | Албан шаардлага хүргүүлэх | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Б.Лхагвамандал, А.Соёл-Эрдэнэ |
| 2 | Орлого бүрдүүлэлттэй холбоотой | Татварын орлогын төлөвлөгөөг 28.1 хувиар, 7 нэр төрлийн орлогыг тасалж, татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлтийн хангах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй | 279,710,600.00 | Албан шаардлага хүргүүлэх | Хүлээн зөвшөөрсөн. | Биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор | Албан шаардлага хүргүүлэх | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Б.Лхагвамандал, А.Соёл-Эрдэнэ |
| **Нийт дүн** | | | **279,710,600.00** | | | | | | |

Бэлтгэсэн: Аудитор Т.Оюун-Эрдэнэ

Хянасан: Аудитын менежер Х.Наранцацрал

Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох

Засаг дарга: Б.Лхагвамандал

Санхүүгийн албаны дарга А.Соёл-Эрдэнэ